

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООГ САЙЖРУУЛАХ НЬ: ХАРЬЦУУЛСАН СУДАЛГАА

А.БАТ-ОРГИЛ

УЛС ТӨР СУДЛААЧ

СУДАЛГААНЫ ТАЙЛАНГИЙН ТӨСӨЛ
2021 ОН

© Энэхүү бүтээлийг америкийн ард түмний дэмжлэгээс бүрдсэн АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн тусламжтай, Бүгд найрамдахчуудын олон улсын хүрээлэн, Азийн сангийн хамтран хэрэгжүүлж буй “Залуучууд, эмэгтэйчүүдийн сонгууль, улс төрийн оролцоог идэвхжүүлэх нь” хөтөлбөрийн хүрээнд бүтээв.

Бүтээлд илэрхийлэгдсэн үзэл санаанууд нь уг бүтээлийн зохиогчдын үзэл санаа бөгөөд АНУ-ын Засгийн газар, эсхүл дээрх агентлаг, хүрээлэн, сангийн албан ёсны байр суурь биш болно.



АГУУЛГЫН ТОВЬЁГ

ЗУРГИЙН ЖАГСААЛТ	2
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ	3
ХУРААНГУЙ	4
ОРШИЛ	4
ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ: СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО	5
СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ	8
МОНГОЛЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО БА ҮР НӨЛӨӨ	8
Сонгуулийн тогтолцоо ба намын тогтолцоо	8
Сонгуулийн тогтолцоо ба зохист харьцаа	11
Сонгуулийн тогтолцоо нь институтийн хувьд	13
СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ	15
ИНСТИТУТИЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛАЛТ	16
ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ	20
НОМ ЗҮЙ:	22

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Сонгуулийн тогтолцооны ангилал.....	7
Зураг 2. Үр ашигтай намын тоо, 1992–2020 он (Effective Number of Parties)	10
Зураг 3. Зохист харьцааны индекс, 1992–2020 он	12
Зураг 4: Сонгогчдын ирцийн хувь.....	13

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Улс төрийн намуудын УИХ-д авсан суудлын тоо ба сонгуулийн тогтолцоо..9	
Хүснэгт 2: Суудлын хуваарилалт (Нийслэл ба орон нутаг)14	
Хүснэгт 3. Зарим орны сонгуулийн тогтолцоо15	
Хүснэгт 4: Институтийн орчны харьцуулсан шинжилгээ17	

ХУРААНГУЙ

Энэ судалгаагаар 1992 оноос хойш 2020 оныг хүртэл болсон найман удаагийн парламентын сонгуулийн тогтолцоонд дүн шинжилгээ хийсэн. Ингэхдээ сонгуулийн зохист харьцаа, үр ашигтай намын тоо зэрэг үзүүлэлтүүдийг Сонгуулийн ерөнхий хорооны мэдээлэлд үндэслэн тооцоолсон. Дараа нь Монголын сонгуулийн тогтолцооны үр нөлөөг таван өөр сонгуулийн тогтолцоотой оронтой харьцуулан шинжилсэн. Харьцуулахдаа институтийн орчны харьцуулсан шинжилгээний арга зүйг ашигласан. Монголд нийт найман удаагийн сонгууль хийхдээ дөрвөн өөр тогтолцоог ашигласан бөгөөд таван удаа өөрчлөлт оруулсан нь институтийн хувьд тогтворгүй байдлыг бий болгожээ. Сонгуулийн тогтолцооны хувьд олонхын/дийлэнх олонхын тогтолцоог ашиглаж ирсэн нь нэг нам давамгайлсан улс төрийн тогтолцоог бий болгохоос гадна сонгогчдын санал гээгдэх, сонгуулийн легитим алдагдах нөхцөл байдлыг бий болгож байна.

Түлхүүр үгс: сонгууль, сонгуулийн тогтолцоо, ардчилал, улс төрийн намын систем.

ОРШИЛ

Нэг. Монгол Улс 1992 онд анхны ардчилсан Үндсэн хуулиа баталж, олон намын тогтолцоотой болсноос хойш нийтдээ найман удаагийн парламентын сонгууль зохион байгуулжээ. Энэ найман удаагийн сонгуульд дөрвөн өөр төрлийн сонгуулийн тогтолцоог ээлжлэн туршсан байна. Үүнд 1992, 2008, 2020 онд том тойрог бүхий олонхын (блок сонголтын), 1996, 2000, 2004 онд жижиг тойрог бүхий дийлэнх олонхын (хоёр үе шаттай тогтолцоо), 2012 онд параллель тогтолцоо, 2016 онд жижиг тойрог бүхий олонхын сонгуулийн тогтолцоог хэрэглэсэн байна. Монголд хэрэглэж ирсэн дээрх сонгуулийн тогтолцоонуудыг судлаачид, иргэд, улс төрчид шүүмжилж ирсэн. Жишээлбэл, 2020 оны сонгуулийн дараа ХҮН намаас УИХ-д сонгогдсон Т.Доржханд (2020) “Энэ сонгуулийн системийг дахин ашиглаж болохгүй гэдгийг хатуу ойлгох хэрэгтэй” гэж мэдэгдсэн. Шалтгаан нь олон мандаттай том тойрогт сонгуулийн компани ажил хийхэд зардал их шаарддаг учраас жижиг намд хүндрэлтэй, мөн сонгуулийн санал гээгддэг зэрэг шалтгааныг дурдсан. Үүнийг 2020 оны УИХ-ын сонгуулийн дараа [Kon.mn](http://kon.mn) цахим хуудсанд сонгуулийг пропорциональ хэлбэрээр хийсэн бол МАН 62 биш, 34 суудал, АН 11 биш, 19, “Та, бидний эвсэл” нэг биш, зургаа, “Шинэ эвсэл” суудалгүй үлдэх биш, дөрөв, “Зөв хүн электорат” эвсэл нэг биш, дөрвөн суудал авахаар байна гэж харуулсан. 2020 оны блок сонголтын тогтолцоонд сонгогчдын санал хэрхэн алдагдаж байгааг үүгээр харуулсан юм. Энэ мэтээр Монголд хэрэглэж ирсэн сонгуулийн ялгаатай тогтолцоонууд нь ямар үр дүнг бий болгосныг шинжлэх үүднээс уг судалгааг хийж гүйцэтгэлээ. Сонгуулийн өөр тогтолцоонууд нь ямар үр дагавар дагуулж байгааг харуулахын тулд үр ашигтай намын тоо, сонгуулийн зохист харьцааны индекс зэрэг тоон үзүүлэлтийг хэмжихээс гадна бусад оронтой харьцуулан шинжилсэн.

Хоёр. Монголд одоог хүртэл сонгуулийн тогтолцооны нэр томьёо тогтоогүй байна. Монголчууд 2012 оныг эс тооцвол мажоритар (дийлэнх олонхын) сонгуулийн тогтолцоог ашигласан гэж ярилцдаг. Гэтэл 1996, 2000, 2004 онд хэрэглэсэн сонгуулийн тогтолцоо л “International IDEA”-ийн нээлттэй өгөгдлийн дагуу “мажоритар” гэх ангилалд багтаж болно. Гэхдээ энэ ч бас учир дутагдалтай. Учир нь *мажоритар* буюу дийлэнх олонхын тогтолцоо нь 50%+1 санал авч байж сонгогддог тогтолцоо юм. Гэтэл дээрх гурван оны сонгуульд нэр дэвшигчид 25%+1-ийн санал аваагүй бол хоёр дахь шатны санал хураалт болохоор тусгасан байдаг. 1992, 2008, 2020 онд ашигласан тогтолцоог Монголчууд олон мандаттай мажоритар гэж нэрлэдэг. Энэ тогтолцооны олон улсын нэр томьёо нь блок сонголтын тогтолцоо бөгөөд энэ блок сонголтын тогтолцоо нь мажоритар гэх ангилалд багтдаггүй. Харин 2016 оны сонгууль бол жижиг олонхын буюу олон улсын нэр томьёогоор бол “түрүүлж барианд хүрэх (First Past the Post)” юм. Энэ нь мөн л мажоритар ангилалд багтдаггүй. Энэ мэтчилэн нэр томьёоны зөрөөтэй ойлголтуудыг энэхүү судалгаагаар ялгаж салгахыг оролдсон болно. Тиймээс энэ судалгаанд дараах байдлаар нэр томьёог ашиглалаа.

1. Majoritarian system – дийлэнх олонхын тогтолцоо
2. Proportional system – пропорциональ тогтолцоо
3. Plurality system – олонхын тогтолцоо
4. FPTP – жижиг олонхын тогтолцоо
5. Block voting – Блок сонголтын тогтолцоо
6. Mixed Member Proportional – Холимог пропорциональ
7. Mixed Member Majoritarian – Холимог мажоритар
8. Party fragmentation – Намын системийн ялгарал, хуваагдал
9. Disproportionality – Зохиц байдал

ОНОЛЫН ҮНДЭСЛЭЛ: СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО

Сонгуулийн тогтолцоо гэж юу вэ? Эрдэмтэд, судлаачид олон тодорхойлолт гаргасан байдаг бөгөөд агуулгын хувьд том зөрөө байдаггүй. Тиймээс энэ судалгаанд Австралийн Үндэсний Их Сургуулийн профессор, сонгуулийн тогтолцоо судлаач Бенжамин Райллигийн тодорхойлолтыг ашиглав.. Райллигийн (2012, 4) тодорхойлсноор “Сонгуулийн тогтолцоо гэдэг бол сонгогчдын өгсөн саналыг парламентад (бусад албан тушаалд) суудал болж хувиргаж байгаа ерөнхий дүрэм, процедур юм”. Сонгуулийн тогтолцоо нь гурван гол үүрэгтэй (Райлли, 2004).


1. Сонгогчдын саналыг хууль тогтоох байгууллагад суудал болгож хувиргах;
2. Сонгогдсон төлөөлөгчдөдөө хариуцлага тооцох;
3. Эрх мэдлийн төлөө өрсөлдөж байгаа хүмүүст өрсөлдөөний тактик боловсруулахад нь туслах;

Сонгуулийн тогтолцоог сонгох нь улс төр, эдийн засаг, нийгмийн суурь нөхцөлүүдтэй холбоотой маш чухал шийдвэр юм. Энэхүү шийдвэрийг гаргахдаа хоорондоо зөрчилтэй гэмээр зорилтуудаас эрэмбэлж шийдвэр гаргах шаардлага тулгардаг (IDEA, 2005). Жишээлбэл, сонгогчдын саналыг зөв төлөөлдөг парламенттай больё гэвэл пропорциональ тогтолцоо сонгох шаардлагатай. Гэхдээ энэ нь нөгөө талаараа тогтвортой засаг бий болгох зарчимтай зөрчилдөөд эхэлдэг. Өөрөөр хэлбэл, парламентад сонгогдсон хэт олон намаас хэн нь ч олонх болж чадахгүй байх тохиолдол пропорциональ тогтолцоонд их тохиолддогтой холбоотой. Иймэрхүү олон төрлийн хоорондоо зөрчилтэй зорилгуудаас аль нь илүү чухал гэж үзсэнээ сонгож, сонгуулийн тогтолцоогоо боловсруулдаг байна.

IDEA (2005) буюу Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэнгийн гарын авлагад дурдсанаар сонгуулийн тогтолцоо нь ардчилсан институтүүдийн хүлээн зөвшөөрөгдөх буюу легитимт чанарт нөлөөлж байдаг. Ер нь сонгуулийн систем нь төр засгийг сонгохоос гадна нийгэм дэх зөрчлийг удирдах хэрэгсэл болох ёстой гэж үздэг (IDEA, 2005). Өнөөдөр дэлхийд үндсэндээ таван төрлийн сонгуулийн тогтолцоо байна (Rielly, 2012). Райллингийн (2012) ангиллаар олонхын, дийлэнх олонхын, хагас пропорциональ, пропорциональ, холимог гэсэн төрөлтэй. Олонхын тогтолцоо нь дотроо жижиг олонхын (FPTP), блок сонголтын буюу олон мандаттай том тойргийн гэж хуваагддаг. Харин дийлэнх олонхын буюу мажоритар тогтолцоонд хоёр үе шаттай сонгуулийн тогтолцоо, алтернатив сонголтын тогтолцоо, нэмэлт сонголтын тогтолцоо гурав багтана. Харин пропорциональ буюу хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоо нь дотроо нээлттэй жагсаалт, хаалттай жагсаалт, шилжих саналын гэж хуваагдана. Холимог систем нь үндсэн холимог пропорциональ, холимог мажоритар гэсэн хоёр хэлбэртэй байдаг (Ангиллыг зураг 1-ээс харж болно) (Rielly, 2012).

Дэлхийн нийт 199 орноос 70 орон (35%) нь пропорциональ тогтолцоог ашиглаж байгаа бол жижиг олонхын тогтолцоог 47 орон (24%) ашиглаж байна (IDEA, 2005). Блок сонголтын тогтолцоог 15 оронд ашиглаж байсан бол холимог системийг есөн оронд л ашиглаж байна. Жижиг олонхын тогтолцоог (FPTP) Их Британи, Канада, Энэтхэг, АНУ зэрэг оронд ашиглаж байна. Монголд 2020 онд ашигласан блок сонголтын буюу олон мандаттай олонхын тогтолцоо нь сонгогч нарт хэд хэдэн сонголтыг хийх боломж олгодгоороо жижиг олонхын FPTP-оос ялгардаг (IDEA, 2005). Блок сонголтын тогтолцоог улс төрийн намууд нь сул хөгжсөн орнуудад ашигладаг байна. Жишээлбэл, 2004 онд Кэйманы арлууд, Лаос, Лебан, Тонга, Тувалу зэрэг оронд ашигласан. Түүнчлэн Филиппин, Тайланд зэрэг оронд 1997 онд хэрэглэж байжээ. Гэвч эдгээр орон сонгуулийн үр дүндээ сэтгэл ханамжгүй байсан учраас дараагийн сонгуулиар тогтолцоогоо өөрчилж байсан. Гол сул тал нь таамаглаагүй үр дүн бий болгодог. Жишээлбэл, сонгогчид нэг л намын төлөө өөрт байгаа хоёр, гурван саналаа өгөөд эхлэхээр жижиг олонхын тогтолцооны бүх сул талыг хэд дахин үржүүлчихдэг. Ийм ч учраас блок сонголтын тогтолцоо гэж нэрлэсэн байна. Ялангуяа сонгогчдын өгсөн санал гээгдэх нь жижиг олонхын тогтолцооноос илүү их гэж үздэг. Ингэснээр парламентад сөрөг хүчингүй болох ч аюул нүүрлэдэг болохыг Маурити Улсын 1995 оны сонгуулийн жишээ харуулсан (IDEA, 2005).

Зураг 1. Сонгуулийн тогтолцооны ангилал



Эх сурвалж: Райлли (2012), IDEA (2005) нарын ангилалд үндэслэв

Мажоритар/плюралити сонгуулийн тогтолцоо нь нэр дэвшигчид тухайн орон нутагтаа хүчтэй дэмжлэгтэй байхыг шаарддаг бөгөөд улс төрийн намын хамаарал бага байдаг. Харин намын жагсаалт бүхий пропорциональ тогтолцоо нь улс төрийн намыг байгууллагын хувьд нэн тэргүүнд тавьдаг. Тиймээс улс төрийн намын төлөвшилд эергээр нөлөөлдөг бөгөөд өрсөлдөөн илүү тэнцвэртэй байдаг гэж үздэг (Дуверже, 1951). Жижиг олонхын системийн хамгийн гол үр дүн нь Дуверже (1951)-гийн хууль ёсоор хоёр намын системийг бий болгодог. Энэ тогтолцоогоор ялсан намын гарт бүх эрх мэдэл очдог бөгөөд “ялагч бүгдийг авдаг систем” гэж нэрлэх нь бий. Харин пропорциональ сонгуулийн тогтолцоонд парламентад хэт олон нам гарах, улмаар зөвшилцөж чадахгүй байх, эсвэл тогтмол зөвшилцлийн Засгийн газар байгуулагдаж, эгэх хариуцлага сулрах сул талтай байдаг (Reynolds, 1997). Пропорциональ тогтолцооны хувьд босгыг хэдэн хувьтай тавихаас парламент дахь намын тоог хязгаарлах, эсэх нь шийдэгддэг байна. Бөрк (2003)-ийн үзсэнээр босго өндөр буюу 5-8 хувьтай орнуудад намын тоо хязгаарлагдмал түвшинд байна. Харин сонгуулийн холимог системийн үр нөлөө мөн л ялгаатай. Холимог систем нь плюрал, мажоритар болон пропорциональ системийн дунд зэргийн улс төрийн намын системийг бий болгосон гэдэг (Рейнолдс, Рейлли 1997).

СУДАЛГААНЫ АРГА ЗҮЙ

Энэ тайланг бэлдэхдээ тоон болон чанарын судалгааны аргыг хосолмол байдлаар ашиглав. Эхний хэсэгт өнгөрсөн парламентын сонгуулиудын өгөгдөл дээр үндэслэн тоон шинжилгээ хийлээ. Глахарын (1991) үзэж байгаагаар сонгуулийн тогтолцоог хэмжих хамгийн чухал хоёр үзүүлэлт бол зохист харьцааны индекс (Least squares index of disproportionality), үр ашигтай намын тоо (Effective number of Parties) хоёр юм. Энэхүү хоёр үзүүлэлтээр Монголын сонгуулийн тогтолцоонуудын үр нөлөөг харуулахыг зорьсон болно. Хоёр дахь хэсэгт Монголыг пост коммунист болон Ази, Номхон далайн зарим орны сонгуулийн тогтолцоотой харьцууллаа. Ингэхдээ IDEA-ийн өгөгдлийг ашигласан. IDEA нь Ардчилал, сонгуульд туслах зорилготой олон улсын хүрээлэн бөгөөд уг байгууллагаас сонгуулийн талаарх олон төрлийн өгөгдөл гаргадаг.

Мөн сонгуулийн тогтолцоо ба институтийн орчныг харьцуулахын тулд харьцуулсан институтийн орчны шинжилгээ хийлээ. Ингэхдээ Минтромын (2012) боловсруулсан харьцуулсан институтийн шинжилгээний аргачлалыг ашигласан. Минтромын (2012) тодорхойлсноор институт гэдэг нь хүмүүс болон баг, хамт олны үг, үйлдлүүдийг тодорхойлж байдаг тоглоомын дүрэм (the rule of game) юм. Би харьцуулах кэйсүүдээ сонгохдоо өөр өөр тогтолцоотой орнуудыг сонгосон. Харьцуулсан кэйсийн хувьд хамгийн өөр системийн арга зүйг (most different systems) ашигласан. Үүнд: Унгар (холимог сонгуулийн тогтолцоо), Польш (пропорционал), Австрали (Альтернатив сонголт), Малайз (Жижиг олонхын FPTP), Монгол (Блок сонголтын) багтана.

МОНГОЛЫН СОНГУУЛИЙН ТОГТОЛЦОО БА ҮР НӨЛӨӨ

Судлаачид сонгуулийн тогтолцооны үр нөлөөг хэмжихэд хоёр л гол хэмжүүр хангалттай гэж улс төр судлаач Галахар (1991) үзсэн байдаг. Энэ нь намын системийн хуваагдал (party fragmentation), санал гээгдэх буюу сонгогчдын өгсөн саналын хувь парламентад хэр зэрэг туссан, эсэхийг хэмждэг зохист харьцаа хоёр юм. Нэгдэх үзүүлэлтийг нь үр ашигтай намын тоогоор хэмждэг бол хоёр дахь үзүүлэлтийг Галахарын (1991) зохист харьцааны индексээр хэмждэг. Иймээс би Галахарын шалгуураар Монголын сонгуулийн тогтолцооны үр нөлөөг шинжиллээ.

Сонгуулийн тогтолцоо ба намын тогтолцоо

Монголд 1990 онд анх удаа олон намын өрсөлдөөнт сонгууль зохион байгуулагдсан. Уг сонгуульд нийтдээ зургаан улс төрийн нам өрсөлдсөн ч эрх баригч МАХН парламентын үнэмлэхүй олонхыг бүрдүүлэв. Шинээр байгуулагдсан намуудаас гурав нь парламентад суудалтай болсон. Гэхдээ уг 1990 оны сонгууль бол шилжилтийн үеийн сонгууль бөгөөд шинэ Үндсэн хуулийг батлах зорилготой парламент сонгогдсон. Уг сонгууль өвөрмөц сонгууль байсан гэдгийг олон жишээнээс харж болно. Жишээлбэл, АИХ-ын сонгуульд улс төрийн намуудаас гадна тухайн үеийн

албан байгууллагууд нэр дэвшүүлэх эрхтэй оролцсон. Иймээс анхны ардчилсан Үндсэн хууль батлагдсанаас хойших сонгуулийг дүн шинжилгээ хийхдээ авч үзсэн.

Хүснэгт 1. Улс төрийн намуудын УИХ-д авсан суудлын тоо ба сонгуулийн тогтолцоо

Намууд	1992	1996	2000	2004	2008	2012	2016	2020
Сонгуулийн тогтолцоо	Блок сонголт	Хоёр үе шаттай сонгууль	Хоёр үе шаттай сонгууль	Хоёр үе шаттай сонгууль	Блок сонголт	Параллель	Жижиг олонх (FPTP)	Блок сонголт
МАН	70	25	72	36	45	25	65	62
АН	5	50	1	34	28	31	9	11
МУНН		1						
ИЗНН			1		1	2		
НН					1			
МАШСН			1					
БНН				1				
МАХН						11	1	1
ХҮН								1
Бие даагчид	1	0	1	3	1	7	1	1

Эх сурвалж: СЕХ-ны мэдээлэлд үндэслэв, 2020

1992, 2008, 2020 оны сонгуулиуд блок сонголтын систем буюу Монголд нэрлэж заншсанаар томсгосон тойрог бүхий олонхын системийг хэрэглэсэн байна. Ингэхдээ ихэвчлэн 26 тойрогт хүн амын тоо, газар нутгийн байршил зэргээс хамаарч 2-4 мандатыг хуваарилж байсан. Харин 1996, 2000, 2004 онд хоёр үе шат бүхий сонгуулийн тогтолцоог ашигласан. Ингэхдээ нэр дэвшигч 25%+1-ийн санал аваагүй тохиолдолд хоёр дахь шат зохион байгуулагдахаар хуульчилсан. 2016 оны сонгуульд жижиг тойрог бүхий олонхын системийг ашигласан бөгөөд 76 тойрог тус бүр нэг мандаттайгаар зохион байгуулагдсан. Өөрөөр хэлбэл, барианд түрүүлж хүрсэн нь шагналаа ав (First past the post) гэдэг зарчим хэрэгжсэн гэсэн үг юм. Харин 2012 оны УИХ-ын ээлжит сонгуулийг анх удаа холимог (параллель) хэлбэрээр явуулсан. Ингэхдээ 26 тойрогт 48 суудлыг 1-3 мандаттайгаар, үлдсэн 28 суудлыг намын хаалттай жагсаалтын дагуу хувь тэнцүүлэх зарчмаар хуваарилжээ. Энэ бол олонхын тогтолцоогоор гээгдсэн саналыг нөхөж тооцох тооцоолол хийгдэх боломжгүй учраас параллель тогтолцоо гэж үздэг. Хүснэгт 1 болон зураг 1-тэй харьцуулж харахад Монголд мажоритар (50%+1) буюу дийлэнх олонхын тогтолцоог ашиглаж байгаагүй нь тодорхой харагдаж байна.

1992 оноос өнөөг хүртэл нийт найман удаагийн парламентын сонгууль зохион байгуулагдсанаас МАН (МАХН) зургаад нь олонх болсноос хоёрт нь ердийн олонх, дөрөвт нь дийлэнх олонхыг бүрдүүлжээ. Харин АН хоёрт нь буюу 1996, 2012 онд тус тус парламентад олонх болжээ (Хүснэгт 1). Гэхдээ 1996 онд Ардчилсан нам дангаар

бус, Ардчилсан холбоо эвслээр, 2012 оны сонгуульд МАН-аас арай олон суудал авсан хэдий ч Засгийн газраа байгуулах хэмжээний олонх болж чадаагүй юм. Сонгуулийн тогтолцоо нь Монголд хоёр намын системийг бий болгосон гэж үздэг эрдэмтэд олон бий. Үүнд Кройссант, Колкел (2010), Фиш (1998), Фритц (2012) нар багтана. Гэхдээ дээрх хүснэгтээс харахад Монголын намын систем нь Блонделийн (1968) ангиллаар ноёрхогч намын систем (Dominant party system) гэх ангилалд багтаж байгаа юм. Өөрөөр хэлбэл, сонгуулийн өрсөлдөөн маш сул буюу нэг нам давамгайлсан байдалтай байна гэсэн үг юм.

Үүнийг бүр тодорхой харуулах үзүүлэлт бол үр ашигтай намын тоо (effective number of parties) юм. Лааксо, Таагепера нар үр ашигтай намуудын тоо хэмээх ойлголтыг Рейгийн фракциллын индекс дээр суурилж, 1979 онд анх гаргасан байдаг. Ер нь улс төр судлаачид тухайн улс төрийн намын системд хэдэн тоглогч бодитойгоор өрсөлдөж байгааг харуулахын тулд намын хуваагдал (party fragmentation) гэх ойлголтын хүрээнд сонгуулийн үр ашигтай намын тоо, парламентын үр ашигтай намын тоо гэсэн хоёр гол үзүүлэлтээр хэмждэг.

Үр ашигтай намын тоог дараах байдлаар тооцно (Лааксо, Таагепера, 1979).


Сонгуулийн үр ашигтай намын тоо нь:

$$N_v = \frac{1}{\sum(P_v)^2} \quad P_v \text{ нь намын авсан саналын хувь хэмжээг илэрхийлнэ.}$$

Парламент дахь үр ашигтай намын тоо нь:

$$N_s = \frac{1}{\sum(P_s)^2} \quad P_s \text{ нь намын авсан суудлын хувь хэмжээг илэрхийлнэ}$$

Зураг 2. Үр ашигтай намын тоо, 1992–2020 он (Effective Number of Parties)



Эх сурвалж: СЕХ-ны хорооны мэдээлэлд үндэслэн тооцсон, 2020

- ENEP – Сонгуулийн үр ашигтай намын тоо
- ENPP – Парламентын үр ашигтай намын тоо

Сонгуулийн үр ашигтай намын тоо гэдэг нь сонгуульд хэдэн нам яг хүчтэй өрсөлдөж байгааг харуулдаг. Хэдийгээр сонгуульд 10, 20 нам оролцож болох ч өрсөлдөөн цөөн намын дунд өрнөдөг. Энэ тоо нь бусад пост коммунист орнуудад

ихэвчлэн таваас дээш байдаг бол манайд дунджаар 2.9 байна. Харин парламентын үр ашигтай намын тоо нь хэдэн нам парламентад суудал авч байгааг илтгэдэг. Монголд дээрх найман сонгуулийн дунджаар энэ тоо 1.8 байна. Өөрөөр хэлбэл, нэг нам сонгуулийн үр дүнд ноёлж байгааг харуулж байна. Харин энэ үзүүлэлт пост коммунист орнуудын хувьд ихэвчлэн дөрвөөс дээш байна.

Энэ хоёр үзүүлэлтийг хооронд нь харьцуулснаар тухайн улс төрийн системд хэдэн нам хүчтэй өрсөлдөөд, хэд нь парламентад суудалтай болж байгааг харж болдог. Үүгээр тухайн сонгуулийн тогтолцоо нь хэр зэрэг шударга өрсөлдөөнийг бий болгож байгааг дүгнэж болно. Зураг 2-оос харахад Монголын сонгуульд ихэвчлэн 2-3 нам идэвхтэй, хүчтэй өрсөлддөг боловч парламентад ихэвчлэн нэг л нам ялдаг болох нь харагдаж байна. Ер нь парламентын үр ашигтай намын тоог парламентад 2-4 байвал хэвийн буюу сайн гэж үздэг билээ (Бат-Оргил, Батхишиг, 2020). 1992 оноос хойших үзүүлэлтийг дунджилж үзвэл Монголынх пост коммунист ардчилсан орнууд дотроос хамгийн бага байна. Парламентын үр ашигтай намын тоо Унгарт 2.8, Польшид 4.1 зэрэг байхад Монголд дунджаар 1.8 байна (Бат-Оргил, Батхишиг, 2020). Товчхондоо сонгуулийн үр дүнд нэг л нам ялдаг, өрсөлдөөн багатай улс төрийн намын системийг бүрдүүлэхэд дээрх олонхын буюу ялагч бүхнийг авдаг сонгуулийн тогтолцоонууд нөлөөлсөн гэж дүгнэж болохоор байна.

Хэт цөөн намтай өрсөлдөөн байгаа нь зөвхөн сонгуулийн тогтолцоотой холбоотой биш гэдгийг энд дурдах нь зөв. Өөр олон шалтгаан байж болох бөгөөд үүний нэг нь улс төрийн намын санхүүжилтийн асуудал юм. Монголд зөвхөн парламентын намыг л төсвөөс дэмжиж ирсэн нь шинээр намууд төлөвшихөд сөргөөр нөлөөлсөн байх бүрэн үндэслэлтэй юм (Алтанхуяг, Ганхуяг, 2020).

Сонгуулийн тогтолцоо ба зохист харьцаа


Дээр дурдсан сонгуулийн тогтолцооны нөлөөллийг хэмждэг хоёр дахь үзүүлэлт бол зохист харьцаа (disproportionality) юм. Өөрөөр хэлбэл, сонгууль хийж байгаагийн эцсийн үр дүн нь сонгогчдын санал аль болох тэр хэмжээгээрээ парламентад суудал болж хувирах ёстой гэсэн үг (Райлли, 2007). Монголд ашиглаж ирсэн олонхын зарчмаар сонгогддог сонгуулийн тогтолцоонд маргаан дагуулдаг нэг гол асуудал нь сонгогчдын санал гээгдэх явдал байдаг. Үүнийг хэмжих зорилгоор Майкл Галлахар 1991 онд энэхүү индексийг боловсруулсан юм. Уг индекс нь сонгогчдын санал хэрхэн суудлын тоонд хувирч байгааг тооцоолдог. Өөрөөр хэлбэл, сонгогчдын санал хэр зэрэг гээгдэж буй нь энэ үзүүлэлтээр гарч ирдэг.

Зохист харьцааны индексийг тооцохдоо:

$$LS_q = \sqrt{\left(\sum_i (s_i - v_i)^2\right) / 2}$$

$S_i - V_i$ нь авсан суудлын хувь хэмжээ ба саналын хувь хэмжээний зөрүүг илэрхийлнэ.

Зураг 3. Зохист харьцааны индекс, 1992–2020 он



Эх сурвалж: СЕХ-ны мэдээлэлд үндэслэн тооцов

Уг графикаар хувь хэмжээ нь их байх тусам зохисгүй харьцааг илтгэнэ. Өөрөөр хэлбэл, санал их гээгдэж байна гэсэн үг юм. 1992-оос 2020 оны хооронд нийт найман сонгуулийн дунджаар 18.6 байна. Энэ тоо бусад пост коммунист оронд ойролцоогоор 5-7-гийн хооронд байна (Бат-Оргил, Батхишиг, 2020). Энэ нь Монголд сонгуулийн зохист харьцаа маш их алдагдсаныг тодорхой харуулж байна.

Зураг 3-аас харахад 2004 онд хамгийн бага буюу 0.7%, 2008 онд 5.3% байна. 2004 онд хоёр үе шат бүхий олонхын тогтолцоог хэрэглэсэн бол 2008 онд блок сонголтын тогтолцоогоор сонгууль хийсэн. 2012 онд параллель буюу пропорциональ элементийг сонгуулийн тогтолцоонд (хаалттай жагсаалт) оруулж ирсэн билээ. Пропорциональ хувь тэнцүүлэх системд санал гээгдэх нь маш бага байдаг. Гэхдээ бид нэг зүйлийг анхаарах ёстой бөгөөд 2012 оны сонгууль бол параллель тогтолцоо бөгөөд уг тогтолцоо нь сонгогчдын санал гээгдэх нөхцөлийг алга болгодоггүй онцлогтой систем (Reilly, 2012).

2000 онд хоёр үе шат бүхий олонхын тогтолцоотой байсан бөгөөд зохист харьцааны индекс нь 32.4 байна. Гэтэл яг энэ тогтолцоогоор хийсэн 2004 оны сонгуулийн үр дүнгээр зохист харьцаа 0.7 хувьтай байгаа нь энэ тогтолцооны үед санал гээгдэхгүй ч байх боломжтойг харж болно. Ер нь 2004, 2008, 2012 онд дээрх индекс бага байгаа нь олон шалтгаантай. Сонгуулийн тогтолцоо нь улс төрийн намын системд нөлөөлдөг бол намын систем нь бас сонгуулийн тогтолцоонд нөлөөлдөг. 2004 оноос Монголын улс төрийн намын системд хоёр намын систем төлөвших хандлага тогтож ирсэн. Үүнийг Радченко, Жаргалсайхан нарын 2017 оны өгүүлэлд дурдсан байдаг. Ер нь 2004, 2008 онд голлох хоёр нам сонгогчдын саналыг тун ойролцоо авсан, мөн парламентад ойролцоо суудал авсан. Мөн эвслийн Засгийн газар байгуулагдсан. Өөрөөр хэлбэл, хоёр том намын хамтын ажиллагаа, картел маягийн үйл ажиллагаа 2004 оноос 2012 оныг хүртэл найман жил үргэлжилсэн нь дээрх үзүүлэлтүүдэд нөлөөлсөн гэж дүгнэж болно (Радченко, Жаргалсайхан 2017). 2012 оны хувьд 28 суудалд нь


пропорциональ буюу хувь тэнцүүлсэн учраас санал гээгдэх явдлыг бууруулжээ. Бусад таван удаагийн сонгуульд санал маш их гээгджээ.

Сонгуулийн тогтолцоо нь институтийн хувьд

Нэгт. Сонгуулийн тогтолцоог 30 жилд таван удаа өөрчилсөн болох нь дээрх хүснэгт 1-ээс харагдаж байна. Сонгуулийн тогтолцоо бол өөрөө бие даасан институт гэдгийг дурдах нь зүйтэй (IDEA, 2005). Сонгуулийн тогтолцоо тогтвортой байснаар улс төрийн намуудад тоглоомын дүрэм ойлгомжтой байж шударга өрсөлдөөн гарах нэг нөхцөл бүрддэг. Миний доор харьцуулж буй орнуудад сүүлийн 30 жилд сонгуулийн тогтолцоо нь ихэвчлэн өөрчлөгдөөгүй, эсвэл нэг л удаа өөрчлөгдсөн байсан. Энэ нь Монголд сонгуулийн тогтолцоо ямар ч тогтворгүй байгааг бүрэн илтгэж байна.

Сонгуулийн тогтолцоог өөрчилж ирсэн нь сонгогчдын ирцэд төдийлөн нөлөөлсөнгүй. 1992, 1996, 2000, 2004 онд сонгогчдын ирц өндөр хувьтай байна (Хүснэгт 4). Харин 2012 онд сонгогчдын ирц хамгийн муу байсан нь хачирхалтай үзүүлэлт. Учир нь пропорциональ элемент бүхий сонгуульд иргэд илүү идэвхтэй оролцдог гэсэн ойлголт байдаг.

Зураг 4: Сонгогчдын ирцийн хувь



Эх сурвалж. СЕХ-ны мэдээлэлд үндэслэв.

Хоёрт. Сонгуулийн тойргийн хуваарилалт маш чухал хүчин зүйл байсан. Нийт зургаан удаа олонх болж байсан МАН (МАХН) орон нутагт илүү нэр хүндтэй байсан учраас сонгуулийн тойргийг тэгш бусаар хуваарилдаг байсан гэж судлаач Фритц (2008) үзсэн. Харин 1990 оноос хойш байгуулагдсан намууд нь Улаанбаатарт илүү нэр хүндтэй байлаа (Фритц, 2008). Хэдийгээр хүн амын тал гаруй хувь нь нийслэл Улаанбаатар хотод оршин суудаг ч УИХ-ын суудлын дийлэнх нь орон нутагт хуваарилагдсаар ирснийг дараах хүснэгтээс харна уу.

Хүснэгт 2: Суудлын хуваарилалт (Нийслэл ба орон нутаг)

	1992	1996	2000	2004	2008	2012	2016	2020
Нийслэлд	24	20	20	20	20	14	28	24
Орон нутагт	52	56	56	56	56	34	48	52

Эх сурвалж: СЕХ, 2020

Дээр дурдсан бидний хэрэглэж ирсэн олонхын тогтолцоог шүүмжлэхдээ хувийн улс төрийн тоглолт хийх хөрс суурийг бий болгодог бөгөөд улмаар төсвийг тарамдуулдаг зэрэг нь байгаа оноогүй шүүмжлэл болохыг эндээс харж болно. Учир нь тойргийн хуваарилалт сонгуулийн тогтолцоо гэхээсээ илүүтэй улс төрчдийн сонгогдох тактик (Райлли, 2004) дээр үндэслэсэн байсантай холбоотой байна.

Гуравт. Сонгуулийн тогтолцоо хэдийгээр олон удаа өөрчлөгдсөн ч үндсэндээ хоёр л том өөрчлөлт орсон гэж хэлж болно. Эдгээр хоёр өөрчлөлт нь 2008, 2012 оны сонгуулиуд юм. 2000 оны сонгуульд МАХН супер олонх буюу 72 суудал авсан байсан. Нэгэнт эрх мэдлийг гартаа оруулсан учраас сонгуулийн системийг 2004 онд хэвээр хадгалсан. Гэвч 2004 оны сонгуулиар анх удаа эвслийн Засгийн газар бүрдсэн. Ингэснээр 2005 оноос олон мандаттай буюу блок сонголтын тогтолцоог бий болгох (том намд ашигтай тогтолцоо), сонгуулийн компаниг ажлын санхүүжилтийг нарийн зохицуулах зэрэг асуудлууд хөндөгдөж эхэлсэн (Фритц, 2008). Энэ нь Радченко, Жаргалсайхан нарын дүгнэснээр Монголын улс төрд шинэ үеийг эхлүүлжээ (Radchenko, Jargalsaikhan, 2017).

Монголын сонгуулийн тогтолцоог сайжруулах зорилгоор УИХ-аас санаачлан, Австралийн профессор Райли бодлогын судалгааны ажлыг 2010 онд хийсэн. Райли профессорын (2012) зөвлөмжөөс харахад Монгол шиг оронд бүс нутгийн төлөөллийг тусгасан систем хэрэгтэй. Энэ нь хөдөө аж ахуй, тэр дундаа мал аж ахуй эрхэлдэг иргэдийн хувьд төлөөллөөрөө дамжуулан асуудлаа шийдүүлэх зайлшгүй хэрэгцээ гардагтай холбоотой гэж дүгнэжээ. Тэрээр Монголын парламентад өгсөн зөвлөмждөө холимог систем илүү тохиромжтой гэж зөвлөсөн байдаг. Учир нь Монголтой төстэй гэх Зүүн Азийн болон хуучин Зөвлөлт Холбоот Улсын бүрэлдэхүүнд байсан орнууд түлхүү ашигладаг гэжээ.

Райлли профессорын зөвлөмжийн дагуу хоёр дахь том өөрчлөлт болох 2012 оны сонгуульд таван хувийн босготой намын хаалттай жагсаалт бүхий пропорциональ элементийг агуулсан сонгуулийн тогтолцоо нэвтрүүлсэн. Ийм тогтолцооноос гурав дахь нам хамгийн их хождог. “Шударга ёс” эвсэл 11 суудлынхаа долоог нь намын жагсаалтаар авсан бол Иргэний зориг, ногоон нам зөвхөн жагсаалтаар л УИХ-д суудал эзэлсэн (Maškarines, 2018). Өмнөх сонгуулиудтай харьцуулахад 2012 оны сонгууль нь хоёр нам голлосон улс төрд өөрчлөлт оруулсан (Maškarines, 2018). 2000 онд таван нам нэгдэж, Ардчилсан намыг байгуулсан бол 2012 онд МАХН хуваагдсан байдаг. 2012 оны сонгуульд уг хуваагдал нь сул тал болсон гэж үзэж болно.

Дээрх бүгдийг дүгнээд үзэхэд Монголд найман удаагийн парламентын сонгуулиар блок сонголт, хоёр үе шат бүхий олонхын, жижиг олонхын (FPTP), параллель сонгуулийн тогтолцоонуудыг ашиглаж ирсэн нь “ноёрхогч намын систем” төлөвшихөд нөлөөлжээ. Харин дээрх тогтолцооны үеэр санал гээгддэг буюу иргэдийн сонголт УИХ-д суудал болж хувирч чадахгүй байгааг зураг 2-оос дахин харна уу. Энэ нь сонгуулийн тогтолцоог өөрчлөх хангалттай үндэслэл гэж үзэж болно. Мөн парламентын үр ашигтай намын тоо хэт цөөн байгаа нь мөн л ардчиллын чанарт сөргөөр нөлөөлж буй үзүүлэлт тул сонгуулийн тогтолцоог өөрчлөх шаардлагыг бас дахин харуулсан. Гэхдээ дээр дурдсанчлан сонгуулийн тогтолцоо нь өөрөө институтийн хувьд тогтвортой байх нь чухал үзүүлэлт гэдгийг мартаж болохгүй.

СОНГУУЛИЙН ТОГТОЛЦООНЫ ХАРЬЦУУЛСАН ШИНЖИЛГЭЭ

Дараах хүснэгтээс Монголтой төстэй эдийн засаг, улс төр, нийгмийн нөхцөл байдалтай нийт 25 орон ямар тогтолцоог ашиглаж буйг харж болно.

Хүснэгт 3. Зарим орны сонгуулийн тогтолцоо

Орнууд (хоёр танхим = х)	Сонгуулийн тогтолцоо	Саналын босго (%)	Тойргийн дундаж мандаг	Парламе н-тын хэмжээ	Нээлтэй жагсаалт, эсэх	Женде- рийн квот (%)
Албани	Холимог Пропорциональ	3	11.7	140		30
Армен	Пропорциональ	5	10.2	132	X	25
Азербайжан	Олонхын (жижиг тойрог FPTP)	n/a	1	125		
Беларусь (х)	Олонхын (жижиг тойрог FPTP)	n/a	1	110		
Босни & Херцеговина (х)	Пропорциональ	3	21	42	X	40
Болгар	Пропорциональ	4	7.7	240		
Хорват	Пропорциональ	5	14	150	X	40
Чех (х)	Пропорциональ	5	14.3	200	X	
Эстони	Пропорциональ	5	8.4	101	X	
Унгар	Холимог FPTP-DH	5	1-93	199		
Киргиз	Пропорциональ	7	120	120		
Латви	Пропорциональ	5	25	100	X	
Литва	Холимог - хоёр шаттай сонгууль, пропорциональ	5	1-70	141	X	
Молдав	Холимог (олонхын жижиг, пропорциональ- FPTP-LR)	5	1-50	101		40

Монгол	Блок сонголт	n/a	2.6	76		20
Польш (х)	Пропорциональ	5	21.9	460	X	35
Румын (х)	Пропорциональ	5	7.3	329		
Серби	Пропорциональ	3	250	250		30
Словак	Пропорциональ	5	150	150	X	
Словени (х)	Пропорциональ	4	8	90	X	35
Украин	Холимог (жигжиг тойрог FPTP - Largest Remainder)	5	1-225	450		
БНАСАУ	Холимог (пропорциональ Largest Remainder+ FPTP)	3		300		Сайн дурын
Малайз	Жигжиг олонхын FPTP	-	1	222	X	-
Австрали (х)	Алтернатив сонголт	-		151		Сайн дурын
Шинэ Зеланд	Холимог (ММР = FPTP)	5	1	120		Сайн дурын

Эх сурвалж: Bormann and Golder (2013), IDEA (2020a), Casal Bertoa (2020)

Монгол шиг блок сонголтын тогтолцоог хэрэглэдэг орон энд байхгүйг харж болно. Эндээс 13 орон пропорциональ, долоон улс холимог, гурван орон жигжиг олонхын, нэг улс блок (Монгол) сонголт, нэг нь алтернатив сонголтын тогтолцоог ашиглаж байна. 1990-ээд оны үед ардчиллын гурав дахь давлагаагаар ардчилал руу шилжсэн Зүүн Европын орнууд ихэвчлэн пропорциональ, эсвэл холимог пропорциональ тогтолцоо руу шилжсэн. Мөн 2012 онд Монголын хэрэглэсэн параллель тогтолцоог дээрх орнуудад төдийлөн ашигладаггүй, ялангуяа “пропорциональ + блок сонголт” гэсэн хувилбар байхгүй байгаа нь харагдаж байна. Ер нь Монголын 2012 оны параллель тогтолцоо бол холимог тогтолцоо дотроо муу сонголт байсан нь дээрх үзүүлэлтүүдээс бас харагдсан.

ИНСТИТУТИЙН ОРЧНЫ ХАРЬЦУУЛАЛТ

Сонгуулийн тогтолцоо нь улс төрийн олон институтийн зөвхөн нэг нь бөгөөд бусад институтүүд харилцан уялдаатай оршдог. Энэхүү харьцуулалтыг хийхдээ Майкл Минтроммын (2011) тодорхойлсон аргачлалын дагуу шинжилгээг хийлээ. Уг шинжилгээ нь чанарын судалгааны аргачлал учраас харьцуулах кэйсийн хувьд цөөн байх шаардлагатай. Би пост коммунист Унгар (холимог), Польш (пропорциональ), пост коммунист биш Австрали (алтернатив сонголт), Малайз (жигжиг олонхын) зэрэг орныг сонголоо. Өөр сонгуулийн тогтолцоотой орнуудыг сонгосон нь кэйс сонголтын хувьд хамгийн ялгаатай систем (most different systems)-д хамаарна. Ингэснээр дээрх ялгаатай системүүд нь ямар ижил, эсвэл эсрэг үр дүнг үзүүлж байгааг харуулах юм.

Хүснэгт 4: Институтийн орчны харьцуулсан шинжилгээ

Харьцуулж буй орнууд	Холбоотой институтийн дизайн	Ажиглагдсан практикууд	Ажиглагдсан үр дүнгүүд
Монгол	Блок сонголт	<ul style="list-style-type: none"> Монголын парламент нэг танхимтай, 76 гишүүнтэй бөгөөд 2020 оны сонгуулийг блок сонголт буюу олон мандат бүхий олонхын тогтолцоогоор хийсэн. 1992 оноос хойш дөрвөн өөр төрлийн сонгуулийн тогтолцоо хэрэглэсэн. (FPTP, TRS, MMM Block Voting) Нийт найман удаагийн парламентын сонгууль хийсэн. Зургаан удаад нь МАН олонх (үүнээс дөрөвт нь үнэмлэхүй олонх), нэгт нь АН олон (олонх) суудал авсан. 2004, 2008, 2012 оны сонгуулиудын дараа эвслийн Засгийн газар байгуулагдсан. 	<ul style="list-style-type: none"> Парламентын үр ашигтай намын тоо 1.8 байгаа бол сонгуулийн үр ашигтай намын тоо 2.9 буюу хэт төвлөрсөн Сонгуулийн зохист харьцаа нь 1992 оноос хойших дундаж үзүүлэлтээр 18.6 байна. Намын системийн институтчиллийн 1990 оноос 2019 оны хоорондох дундаж үзүүлэлт 89.1 (Касал Бертоа, 2020) байна. Намын систем институтчилэгдсэн. Ноёрхогч намын системтэй
Унгар	Холимог пропорциональ	<ul style="list-style-type: none"> 2012 онд үндэсний ассамблейн 386 гишүүнийг дараах байдлаар сонгосон. 176 гишүүнийг нь нэг мандагтай тойргоос хоёр үе шаттай сонгуулиар, 146 гишүүнийг пропорциональ таван хувийн босготой. (ММР) 2012 оноос хойш хоёр үе шаттай сонгууль нь FPTP болж өөрчлөгдсөн. 1990 оноос хойш Унгар найман удаагийн сонгууль хийсэн. Нэгээс бусад тохиолдолд нь эвслийн Засгийн газар байгуулагдсан. Фидец нам, Унгарын социалист нам, Ардчилсан форум зэрэг нам өрсөлддөг. 	<ul style="list-style-type: none"> Парламентын үр ашигтай намын тооны (1990-2020) дундаж нь 2.6 бол сонгуулийн намын тоо нь 4.1 байна (whogovernseurope, 2020) Сонгуулийн зохист харьцаа нь дээрх хугацаанд дунджаар 12.2 байна. (whogovernseurope, 2020) Намын системийн хувьд институтчилэгдсэн буюу 1990 оноос хойших дундаж үзүүлэлт 88.6 байна Хоёр блок бүхий намын систем
Польш	Пропорциональ	<ul style="list-style-type: none"> Польшийн парламент хоёр танхимтай. Доод танхимын 460 гишүүнийг нээлтэй жагсаалт бүхий пропорциональ (Суудлыг D'Hondt аргаар таван хувийн босготой), дээд танхим буюу сенатын сонгуулийг жижиг олонхын FPTF-аргаар сонгодог. 	<ul style="list-style-type: none"> Парламентын үр ашигтай намын тоо нь 4.1 байна. Харин сонгуулийн үр ашигтай намын тооны 1991-2019 оны дундаж нь 5.9 байна. (whogovernseurope, 2020) Сонгуулийн зохист харьцаа

		<ul style="list-style-type: none"> • 1991-2019 оныг хүртэл нийтдээ найман удаа парламентын сонгууль болсон ба долоон удаад нь хэн ч олонх болж чадахгүй эвслийн Засгийн газар байгуулсан. 	<p>(disporpotionality) нь дээрх дунджаар 8.3 байна. (whogovernseurope, 2020)</p> <ul style="list-style-type: none"> • 1991 оноос хойших намын системийн институтчиллийн дундаж үзүүлэлт 82.3 байна. • Олон туйлт намын систем (Multipolar party system)
Малайз	Жижиг тойрог/олонхын	<ul style="list-style-type: none"> • Төлөөлөгчдийн танхимын 222 гишүүнийг FPTP тогтолцоог ашиглаж сонгодог. • Үндэсний фронт (Барисан нам) 1973 оноос 2018 онд Бакатан Харапан (DAP, PKR, Amanah, Warisan, UPKO нар) эвсэл ялах хүртэл сонгуульд ялж байсан. 	<ul style="list-style-type: none"> • 2008 оноос хойших сонгуулийн үр ашигтай намын тоо нь зургаа, парламентын үр ашигтай намын тоо нь 5.4. (Gallagher, 2019) • Сонгуулийн зохист харьцааны индексийн 2008-2018 оны дундаж нь 9.3 байна. (Gallagher, 2019)
Австрали	Альтернатив сонголт*	<ul style="list-style-type: none"> • Австралийн парламент хоёр танхимтай бөгөөд доод танхимын 151 төлөөлөгчийг алтернатив сонголтын тогтолцоогоор сонгодог бол дээд танхимын 76 гишүүнийг нэг шилжих боломжтой саналын тогтолцоогоор сонгодог. • 1990 оноос хойш Хөдөлмөрийн нам, эсвэл Либерал нам, Үндэсний намын эвсэл Засгийн газраа байгуулж байсан. (Хөдөлмөрийн нам дөрвөн удаа, “Эвсэл” долоон удаа Засгийн газраа байгуулсан. Эндээс 2010 онд Хөдөлмөрийн нам гурван бие даагч, ногоон намын нэг гишүүний хамтаар засгийг байгуулсан) 	<ul style="list-style-type: none"> • 1990-2020 оны хоорондох сонгуулийн үр ашигтай намын тоо нь 3.6 байгаа бол парламентын үр ашигтай намын тоо нь 2.7 байна. (Gallagher, 2019) • Сонгуулийн зохист харьцааны индексийн дундаж нь 10 хувьтай. (Gallagher, 2019) • 1x1+1 намын системийг бий болгосон.

- *Алтернатив сонголтын тогтолцоо нь дийлэнх олонхын тогтолцооны нэг төрөл юм. Нэр дэвшигч 50%+1 хувийн саналаар сонгогддог учраас сонгуулийн болон гишүүдийн легитимт чанарыг сайжруулдаг. Уг тогтолцоонд сонгогчид нэр дэвшигчдийг нэг, хоёр, гурав дахь сонголт гэж дугуйлна. Сонгуулийн дүнд аль ч нэр дэвшигч нь дийлэнх олонх буюу 50%+1 хувийн санал аваагүй бол хоёр дахь, гурав дахь сонголтуудыг тооцож, хэн нэг нь олонхын саналыг авах хүртэл явна. Ингэхдээ хамгийн бага санал авсан хүмүүсийг хасах маягаар үргэлжилдэг. Алтернатив сонголтын тогтолцоо нь Ренвикийн (2011) тодорхойлж байгаагаар сонголтын хувилбаруудыг нэмэгдүүлдэг. Мөн тактикийн сонголтыг багасгадаг.*

- Энэ тогтолцоог Австралиас гадна Папау Шинэ Гвиней, Фижи зэрэг улсад хэрэглэдэг. 2000 онд Босниа Улс алтернатив тогтолцоог орон нутгийн сонгуульд ашиглаж байсан. Мөн сүүлийн үед АНУ-д хэд хэдэн мужид хэрэглэснээр олны анхаарлыг татах болсон (Reilly, 2004). Жишээлбэл, 2002 онд Сан Франциско алтернатив сонгуулийн тогтолцоог ашигласан.

Дээрх таван өөр тогтолцооны үр дагавраас дүгнэхэд:

- Польшийн жишээн дээрээс харахад пропорциональ тогтолцоо нь хэт олон улс төрийн намын хуваагдалд хүргэх, улмаар байнга эвслийн Засгийн газар байгуулагдах асуудалд хүргэж буйг харж болно. Пропорциональ тогтолцоо учраас санал гээгдэх нөхцөл нь бага байна.
- Унгарын холимог пропорциональ тогтолцоо бол парламентын үр ашигтай намын тоо 2.6, сонгуулийн үр ашигтай намын 4.1 буюу өрсөлдөөн харьцангуй зөв явж байгааг харуулж байна. Гэвч зохист харьцааны индекс харьцангуй өндөр байна.
- Малайзын хувьд Монголд 2016 онд ашигласан жижиг олонхын тогтолцоог хэрэгжүүлдэг. Хэдийгээр үр дүнд нь нэг нам ноёлдог боловч бусад олон нам суудал авдаг. Мөн л ноёрхогч намын систем байгаа нь харагдаж байна. Монголоос ялгаатай нь парламентад харьцангуй олон намын төлөөлөлтэй.
- Австралийн сонгуулийн алтернатив тогтолцоо нь өрсөлдөөнийг 3-4 намын хүрээнд хязгаарладаг ба парламентад 2-3 нам л суудал авдаг гэсэн үг. Сонгуулийн зохист харьцаа нь 10 хувьтай байгаа нь дээрх харьцуулж буй орнууд дундаа дундаж үзүүлэлт юм.

Сонгуулийн тогтолцоо нь намуудын ялгарлыг (fragmentation) дэмжихээс гадна улс төрийн намуудыг төлөвших, институтчилэгдэхэд туслах ёстой. Ингэхдээ хэт их хуваагдал, экстрим улс төр бий болгож улмаар Засгийн газар тогтворгүй байдал руу орохоос сэргийлэх учиртай юм (Касал Бертоа, 2020). Энэ шалгуураар харвал Унгар, Австрали хоёрын тогтолцоо нь илүү нийцтэй байна гэж хэлж болно.

ЗӨВЛӨМЖ, ДҮГНЭЛТ

- Монголчууд 1992 оноос хойш сонгуулийн тогтолцоогоо таван удаа өөрчилсөн бөгөөд дөрвөн өөр тогтолцоо туршиж үзжээ. Энэ бүх өөрчлөлтүүдийн үр нөлөө нь сонгуулийн өрсөлдөөнийг хэт нэг намд төвлөрсөн байдалтай болгож байгаа нь харагдсан. Өөрөөр хэлбэл, сонгуулийн өрсөлдөөн 2-3 намын хооронд өрнөөд эцэст нь нэг нам л сонгуульд ялж байна (сонгуулийн үр ашигтай намын тоо 2.9, парламентын үр ашигтай намын тоо 1.8). Мөн сонгуулийн зохист харьцаа алдагдсан буюу дунджаар 18 хувьтай байгаа нь бусад харьцуулсан орнуудаас хол зөрөөтэй байна. Сонгогчдын санал олноор гээгдсээр байгаа нь цаашид сонгуулийн “легитимт” чанар алдагдах нөхцөл байдлыг бий болгох эрсдэлтэй тул өөрчлөх шаардлагатай юм. Ялангуяа блок сонголтын тогтолцоог манайхтай ижил төстэй орнуудад огт ашиглахгүй байгааг анхаарах шаардлагатай.
- Харьцуулсан судалгаанаас харахад пропорциональ тогтолцоо нь хэт олон намууд гарах, тэр дундаа экстрим улс төрийн хүчнүүд гарах, улмаар Засгийн газар тогтворгүй байх нөхцөл рүү оруулах эрсдэлтэй (Унгар, Польш зэрэг орнуудад ардчиллаас ухрах үйл явц өрнөж буй). Засгийн тогтвортой байдалд олон хүчин зүйл нөлөөлдөг бөгөөд үүний нэг нь сонгуулийн тогтолцоо юм (IDEA, 2005). Пропорциональ, эсвэл пропорциональ давамгайлсан сонгуулийн тогтолцоонд ихэвчлэн эвслийн Засгийн газар байгуулагддаг гэдгийг дээрх харьцуулсан жишээнээс харсан. Сонгуулийн үр дүнд эвслийн Засгийн газар байгуулагдсанаар иргэд нь дараагийн сонгуулиар хариуцлага тооцоход хүндрэлтэй байдаг. Өөрөөр хэлбэл, дээр дурдсан гурван том зорилтын нэгийг хангаж чадахгүй байгаа юм.
- Райлли (2010) профессорын зөвлөсөнчлөн Монголын нүүдлийн мал аж ахуйтай (соёл, эдийн засаг, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн онцлог) холбоотойгоор бүс нутгийн төлөөллийг тусгасан сонгуулийн систем хэрэгтэй. Монголд ашигласан олонхын, дийлэнх олонхын тогтолцоонууд нь энэ утгаараа давуу талтай байгааг дурдах хэрэгтэй.
- Тиймээс энэ бүгдийг харгалзан Монголын нөхцөлд алтернатив сонгуулийн тогтолцоог ашиглавал өнөөгийн ноёрхогч намын системийг өөрчилж, сонгуулийн зохист харьцааг хэвийн түвшинд барих буюу санал гээгдэж байгааг өөрчилж чадна. Хамгийн гол нь 1992, 2008, 2020 онд хэрэглэсэн блок сонголтын тогтолцоо нь алтернатив сонголтын тогтолцоог нэвтрүүлэхэд хөрс суурь нь болж чадна. Уг тогтолцоог хэрэгжүүлэхийн тулд эхлээд нөхөн сонгуульд туршилт хийж болно. Алтернатив сонголтын тогтолцоог нэвтрүүлэхээр болбол Сонгуулийн ерөнхий хорооны албан хаагчдыг дахин сургах, программчилсан тооцоололд илүү их найдах хэрэг гарах бөгөөд сонгуулийн үр дүн өмнөхөөс арай удаан гарах зэрэг сул талтай (Трелфол, 2010). Мөн Трелфолын (2010) үзэж байгаагаар эмэгтэйчүүд болон нийгмийн цөөнхийн төлөөлөл багатай орчныг энэ систем сайжруулж чадахгүй.

- Сонгуулийн төгс тогтолцоо гэж байдаггүй бөгөөд сонгуулийн төгс тогтолцоог хайх нь өөрөө төөрөгдөлд хүргэдэг гэдгийг санах хэрэгтэй. Учир нь дээрх бүх л тогтолцоо өөрийн давуу, сул талуудтай. Дээрх харьцуулсан орнууд 1991 оноос хойш сонгуулийн тогтолцоондоо үндсэн өөрчлөлт оруулаагүй. Гэтэл Монгол Улсын хувьд дөрвөн удаа том өөрчлөлт хийчхээд байна. Энэ нь сонгуулийн тогтолцоог институтийн хувьд бэхжихэд сөргөөр нөлөөлөөд зогсохгүй намуудын төлөвшил, институтэд ч сөргөөр нөлөөлж байна.
- Эцэст нь хэлэхэд сонгуулийн тогтолцоотой холбоотой нэр томъёо ойлголтын зөрөө маш их байгааг дээр дурдсан. Энэ нь олон асуудлуудыг бий болгож учраас нэр томъёоны тал дээр судлаачид, сэтгүүлчид, улс төрчид нэгдсэн ойлголтод хүрэх, цаашид иргэд, сонгогчдод таниулах зайлшгүй шаардлагатай байна.

НОМ ЗҮЙ:

- Altankhuyag.B and Gankhuyag.B (2020). Party System Institutionalization in Mongolia. Defacto Institute publishing. Ulaanbaatar
- Blondel, J. (1968) Party systems and patterns of government in Western democracies, *Canadian Journal of Political Science*, 1, pp. 180–203.
- Bormann, N. C., & Golder, M. (2013). Democratic electoral systems around the world, 1946–2011. *Electoral Studies*, 32(2), 360-369.
- Birch S. (2003) Party System Stability and Change. In: *Electoral Systems and Political Transformation in Post-Communist Europe. One Europe or Several?*. Palgrave Macmillan, London
- Croissant, A. & Völkel, P. (2010) Party system types and party system institutionalization: Comparing new democracies in East and Southeast Asia. *Party Politics*, 18:2, 235-265
- Duverger, M. (1954). *Political Parties: Their Organisation and Activity in The modern State*. Methuen & Company.
- Gallagher, M. (1991) Proportionality, disproportionality and electoral systems, *Electoral Studies*, 10(1), pp. 33–51.
- Gallagher, M. (2019) Election indices dataset at http://www.tcd.ie/Political_Science/people/michael_gallagher/EISystems/index.php, accessed [date].
- Kopecký, P. (1995). Developing party organizations in East-Central Europe: what type of party is likely to emerge?. *Party Politics*, 1(4), 515-534.
- Fritz, V. (2002) Mongolia: Dependent Democratization, *Journal of Communist Studies and Transition Politics*, 18:4, 75-100
- Fish, M. S. (1998). Mongolia: democracy without prerequisites. *Journal of democracy*, 9(3), 127-141.
- Fritz, V. (2008) Mongolia: The Rise and Travails of a Deviant Democracy, *Democratization*, 15:4, 766-788
- Laakso, M. & Taagepera, R. (1979) Effective number of parties: A measure with application to Western Europe, *Comparative Political Studies*, 12, pp. 3–27.
- Maškarinec, P. (2018). The 2016 Electoral Reform in Mongolia: From Mixed System and Multiparty Competition to FPTP and One-Party Dominance. *Journal of Asian and African Studies*, 53(4), 511-531.
- Maškarinec, P. (2017). Testing Duverger’s law: strategic voting in Mongolian elections, 1996–2004. *Post-Soviet Affairs*, 33(2), 145-160.
- Mintrom, M. (2011). *Contemporary policy analysis*. Oxford University Press.
- Rae, D. (1967) *The Political Consequences of Electoral Laws* (New Haven, CT: Yale University Press).
- Radchenko, S., & Jargalsaikhan, M. (2017). Mongolia in the 2016–17 electoral cycle: The blessings of patronage. *Asian Survey*, 57(6), 1032-1057.
- Reilly, B. (2012). Electoral system options for Mongolia. *UNDP Consultancy Report*.

- Reilly, B. (2007) *Electoral and political party reform*. In: McLeod, R.H. and MacIntyre, A., (eds.) *Indonesia: Democracy and the Promise of Good Governance*. Institute of Southeast Asian Studies, Singapore, pp. 41-54.
- Reilly, B. (2004). The global spread of preferential voting: Australian institutional imperialism?. *Australian Journal of Political Science*, 39(2), 253-266.
- Renwick, A. (2011). The Alternative Vote. *Political Studies Association*.
- Reynolds, A., Reilly, B. and Ellis, A. (2008) *Electoral system design: The new international IDEA handbook*. International Institute for Democracy and Electoral Assistance, Stockholm, Sweden.
- Reynolds, A., & Reilly, B. (1997). The international IDEA handbook of electoral system design (Vol. 1). International idea.
- International Institute for Democracy and Electoral Assistance (Stockholm). (2005). *Electoral System Design: The New International IDEA Handbook*. International Idea.